



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

212 /212/

2021.12.28

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ



МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ-110 ЖИЛ

ХАД ЧУЛУУ ДЭРЛЭЖ, ХАГАЦАЛ ЗОВЛОН ТУУЛЖ, МАХРАН ТЭМЦСЭНИЙ ЭЦСИЙН ҮР ДҮН НЬ ХХ ЗУУНЫ МОНГОЛЧУУДЫН ТҮҮХЭН ОЛОЛТ МОНГОЛ УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛ

Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын 110 жилийн ойн хүндэтгэлийн хуралд Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Г.САЙХАНБАЯРЫН тавьсан илтгэлийг бүрэн эхээр нь хүргэж байна.



Эрхэм хүндэт Монгол Улсын Их Хурлын дарга аа!

Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад сэтгэл оюунаа дайчлан хичээн зүтгэж байсан үе үеийн Батлан хамгаалахын сайд нар аа!

Монгол Улсын эрх чөлөө, тусгаар тогтнол, газар нутгийнхаа бүрэн бүтэн байдлыг халуун амь, бүлээн цусаараа хамгаалан тэмцсэн хүндэт ахмад дайчид аа!

Батлан хамгаалах үйлсэд залуу нас, оюун ухаан, хөдөлмөр бүтээлээ зориулсан бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмадууд аа!

"Монгол Улсынхаа төлөө зүтгэе" хэмээн эх орон, төр, ард түмэндээ үнэнчрээр зүтгэхээ андгайлан тангарагласан Зэвсэгт хүчний ариун жагсаалд байгаа генерал, офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны түүрүүч, байлдагч нар аа!

Дэлхийн халуун цэгүүдэд энх тайван, амар амгаланг сахиулах үүргээ нэр төртэй гүйцэтгэж байгаа монголын цэнхэр дуулгат энхийг сахиулагчид аа!

Монгол Улсад суугаа гадаад улсын Элчин сайд, Батлан хамгаалахын атташе нар аа!

Та бүхэндээ Монгол Улсад үндэсний эрх чөлөөний хувьсгал өрнөж, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны болон Богд хаант Монгол Улсын "Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яам" буюу өнөөгийн Батлан хамгаалах яамны түүхт 110 жилийн ойн баярын халуун мэндчилгээг өргөн дэвшүүлье!

Дэлхийн түүхээс арчигдах шахан ертөнцийн хязгаарт мартагдаж байсан Монголын ард түмний өөрийн үндэстний оршин тогтнохын төлөө тэмцлийг эхлүүлсэн 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгал бол Монгол

түмнийг сэрээсэн, үндэстний хувьд ахин сэргэн мандах эхлэлийг тавьсан Та бидний хүндэтгэн дурсаж, ёслон тэмдэглэж байх түүхэн гавьяат үйл явдал мөн билээ.

Эх орныхоо тусгаар тогтнол, ард түмнийхээ эрх чөлөөг эрхэмлэн тэмцэгч бидний өвөг дээдэс маань 110 жилийн тэртээх тэр цагагчин гахай жил Үндэсний эрх чөлөөний хувьсгалыг ялалтад хүргэж, туурга тусгаар Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улсаа тунхаглан, магнай тэнийж байсан тэр цаг үе эдүгээ 110 жилтэйгээ золгож байна.

Богд хааны зарлиг 1911 оны 12-р сарын 29-ний өдөр гарч 5 яам байгуулсны нэг нь Цэргийн яам байсан бөгөөд Сэцэн хан аймгийн засаг, бэйс Галсанцэвэгмэдийн Гомбосүрэнд үе улиран Эрдэнэ далай цол, төрийн жүн ван, улбар шар жолоо шагнаж, Шадар сайд, Цэргийн хэргийг бүгд захиран

шийтгэгч яамны тэргүүн сайдын тушаалд тохоон талбисан тэр өдрөөс Монгол Улсын Батлан. Хамгаалах Яам үйл ажиллагаагаа эхлүүлж, эх орныхоо тусгаар тогтнолын манаанд зогсож иржээ.

Тулгар төрийн яамдын тэргүүн, дэд сайдууд Монголын төрд үнэнчээ илэрхийлэн "...дотоодод болбоос тус тусын үнэн шударгыг илэрхийлэн, гадаадад болбоос аюулт дайснаас аянга цахилгаан мэт буцалтгүй улсын сүрийг бадруулан хаан эзний өмнөөс шашин, төрийн тул зүтгэхэд хялбарыг эрэхгүй, бэрхээс зайлахгүй, эдүгээгийн байгуулсан төрийн тул энэхүү батлан тогтоосон тангараг сахилгыг нүдний цөцгий, зурхний толыг мэт хичээнгүйлэн хайрлана" хэмээн чин санаагаар тангараг өргөж байжээ.

Цэргийн Яамны шүтээнээр монголчуудын дайны бурхан хэмээдэг Жамсран буюу Улаан сахиус, Яамны тайлгат уулаар Баянзүрх хайрхныг сонгожээ. Цэргийн яамны тугны дэвсгэр нь шар, голд бадамтай соёмбо, түүний дөрвөн талд дөрвөн хүчтэний нэр байхаар зохиосон нь төр шашныг хослон барих, эрх чөлөөгөө илэрхийлсэн утгатай байлаа.

Богд хаант Монгол улсын үед Цэргийн яамнаас хэрэгжүүлсэн нэн чухал үйл хэрэг бол Хатанбаатар Магсаржав, манлай ван Дамдинсүрэн нар Ховдыг чөлөөлсөн мөн түүнчлэн "Таван замын байлдаан" гэж алдаршсан байлдааны ажиллагаа байлаа. Монголчууд гадны ямар нэгэн улс орны дэмжлэг тусалцаа оролцоогүйгээр өөрсдийн цэргийн хүчээр бие даан манжаас Ховдыг бүр мөсөн чөлөөлж, гадны түрэмгийлэгчдийг эх нутгаасаа хөөж чадсан явдал бол монгол үндэстний хувьд итгэл найдварыг нь сэргээж, цаашдын тэмцэлд нь түлхэц өгсөн түүхэн үйл явдал болсон юм.

Монголын өмнө хязгаар 1913 оны нэгдүгээр сард түгшүүртэй болж, улсын хилд хятадын цэрэг хүч хуралдуулах болсон тул Өвөр Монголын нутагт 5 замаар цэрэг оруулах түүхэн шийдвэр гаргажээ. Эл цэрэг 1913 оны турш Өвөр Монголын нутагт хятадын цэргийн давуу хүчний эсрэг хүнд ширүүн байлдаан хийж байсан билээ. Өвөр Монголд байлдаж байсан Монголын цэргийг улсын хилд татахыг Хиагтын гурван улсын хэлэлцээр дээр Хаант Орос, Дундад иргэн улсын төлөөлөгчид удаа дараа шаардсаар байв. Энэ нөхцөлд Монгол Улсын Засгийн газар арга буюу "харьяат

цэргүүдийг бүрнээ хойш ухруулан, мөн цэргүүдээс татан буулгаж, цөөтгөн суулгаваас" зохих арга хэмжээг авахад хүрсэн юм.

Энэ үед цэргийн зэвсэг хэрэгслийг бэлтгэх, хуваарилах нь маш чухал ажил байв. Байлдааны хурдан буу, пулемёт, артиллерийг Хаант Орос улстай байгуулсан хэлэлцээний дагуу хүлээн авч байсан нь 1911-1919 онд Монгол Улсад үндэсний цэргийг байгуулж, эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг хамгаалан тэмцэх бололцоог монголчуудад олгож байсан байна.

Улс төрийн нөхцөл байдал хүнд хэцүү тэр цаг үед Монголын ард түмэн нэгдэн нийлж, хувьсгалын хоёр дахь давлагааг эхлүүлсэн нь 1921 оны ардын ардчилсан хувьсгал байлаа. Чухамхүү Хиагтад эхэлсэн хувьсгалын буун дуу нь Монгол орны хувь заяаг тэр чигт нь өөрчилсөн түүхэн үйл явдал болжээ.

Хорьдугаар зууны эхээр Монголчууд зэвсэг барин тэмцэж эрх чөлөө, тусгаар тогтнолоо олохын хөөр бахархлыг эдэлсэн билээ. Энэ бол Эзэн Чингис хаанаас хойш 700 жилийн дараа заяасан хувь тавилан, монголчуудын сэргэн мандлын эхлэл байлаа. Энэ бол «Давшгүй давааг давбаас дээр нь гарюу, гэтэлшгүй мөрнийг гэтэлсүгэй хэмээн нэгдвээс тэртээ нь гарюу» гэсэн Их Эзэн Чингис хааны гэрээслэлийн бодит биелэл байв.

Ийнхүү хад чулуу дэрлэж, хагацал зовлон туулж, махран тэмцсэний эцсийн үр дүн нь ХХ зууны монголчуудын түүхэн ололт - Монгол Улсын тусгаар тогтнол байлаа.

Монгол улсаа манжийн эрхшээлээс салгаж, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсан 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ялалт ба Ардын журамт цэрэг Хиагт, улмаар Нийслэл хүрээгээ чөлөөлж, харийн дайснаас эх орноо цэвэрлэсэн Үндэсний ардчилсан хувьсгалын ялалт, Монголын Ардын хувьсгалт цэргийн 1939 оны Халхын голын дайн, 1945 оны Чөлөөлөх дайнд байгуулсан байлдааны ялалт, энх цагийн бүтээн байгуулалтад манай цэрэг дайчдыг зохион байгуулан оролцуулсан их бүтээн байгуулалт, эх дэлхийн энх амгалангийн төлөөх энхийг сахиулах үйлсэд Монголын энхийг сахиулагч цэрэг эрсийн баатарлаг

Үргэлжлэл нь арын нүүрт

ХАД ЧУЛУУ ДЭРЛЭЖ, ХАГАЦАЛ ЗОВЛОН ТУУЛЖ, МАХРАН ТЭМЦСЭНИЙ ЭЦСИЙН ҮР ДҮН НЬ ХХ ЗУУНЫ МОНГОЛЧУУДЫН ТҮҮХЭН ОЛОЛТ МОНГОЛ УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛ

Түрүүч нь эхний нүүрт

үйлс, Монгол Улсын нийгэм-улс төрийн тогтолцооны шинэчлэлээр нөхцөлдөж буй улс орны батлан хамгаалах шинэ тогтолцоог бүрдүүлэх, Зэвсэгт хүчнийг шинэчлэх, тэр бүгдийг ялалт, амжилтад залуурдагч нь манай батлан хамгаалах яам байсаар ирсэн, байсаар ч байгаа билээ.

Батлан хамгаалах яам нь 1911 оноос Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яам, 1922 оноос Ардын эрхт Монгол Улсын цэргийн явдлын яам, 1924 оноос БНМАУ-ын Цэргийн явдлын яам, 1949 оноос Улсыг Батлан хамгаалах яам, 1955 оноос Цэрэг ба Нийгмийг аюулаас хамгаалах хэргийг эрхлэх яам, 1959 оноос Ардын цэргийн хэргийг эрхлэх яам, 1968 оноос Батлан хамгаалах яам хэмээн албан ёсоор нэрлэгдэж ирсэн бөгөөд ийнхүү нэр солигдох бүхэнд түүний ажил үүргийн чиглэл, хүрээ ямар нэгэн хэмжээгээр өөрчлөгдөж ирсэн байдаг.

Ажил үүргийн цар хүрээ хэдий өөрчлөгдөвч: нэгт, Монгол Улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалан сахиж үүргээ нэр төртэй биелүүлсээр иржээ; хоёрт, улс орон, ард түмнийхээ нэгэн эд эсийн хувьд туулсан замналынхаа аль ч үе шатанд нийгэмд тодорхой үүрэг гүйцэтгэж, Монгол Улсын бүтээн байгуулалт соёл, боловсролын хөгжилд гар бие оролцсоор байна; гуравт, арми, ард түмний амин холбоог бэхжүүлж, үе үеийн залуусыг үндэсний эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулж ирсэнд батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын түүхэн гавьяа оршиж байгаа юм.

Батлан хамгаалах яамны түүх бол бүхэлдээ шинэ үеийн монгол цэргийн түүх, батлан хамгаалах байгууллагуудын түүх, тэдгээр түүхийг бүтээгч эрдэм чадлаараа шалгарч шигшигдэн төрийн цэргийн төв байгууллагад ажиллаж байсан сайдууд, генералг, офицер, ахлагч, цэрэг дайчид, энгийн ажилтан албан хаагч хүн бүрийн хийгээд хамт олны түүх юм.

Олон улсын нөхцөл байдал хувьсан өөрчлөгдөж, капиталист ба социалист их гүрнүүдийн хоорондын зөрчил эрс хурцадсан

өнгөрсөн зууны дунд үеэс Монголын Ардын армийг мотобуудлагын бригад, хороо, тусгай мэргэжлийн цэргийн ангиуд бүхий мотобуудлагын цэрэг болгон өргөтгөх, улмаар мотобуудлагын дөрвөн дивиз, төрөл, тусгай мэргэжлийн цэргийн бригад, хороо бүхий ерөнхий цэргийн армийн бүтцэд шилжүүлэх зохион байгуулалтын нүсэр өөрчлөлт, бүтээн байгуулалтын асар их үйлсийн ачааны хүндийг тухайн үеийн Батлан хамгаалах яам үүрч гарсан юм.

Энэ үеийн Монгол Улсын батлан хамгаалах бодлого нь Зөвлөлт Холбоот Улстай холбоотон улсын зарчмаар тогтоосон хамтын ажиллагаанд тулгуурлан тус улсын бүх талын тусламж, дэмжлэгт тулгуурлаж байсан билээ. Монголын ардын армийн хөгжлийн хамгийн оргил үе, бүс нутагтаа дээгүүрт орох армийг байгуулах үйл хэргийн үр дүнг Б.Дорж, Ж.Авхиа, Ж.Ёндон зэрэг тухайн үеийн Батлан хамгаалах яамны сайд-генералууд, тэдгээрийн тэргүүлсэн яамны хамт олны хичээл, зүтгэлтэй холбон үзэх нь зүйд нийцэх билээ.

Монгол Улсад ардчилсан хувьсгал өрнөж, нийгэм-улс төрийн шинэ харилцаанд шилжих үед дэлгэмэл шахам байсан дайчилгааны армийг цомхон болгон хураах, улмаар мэргэжлийн чиг хандлагатай Зэвсэгт хүчин болгон өөрчлөх бүтэц зохион байгуулалтын, цэргийн бие бүрэлдэхүүний нөхөн хангалтын, тэдний сургалт бэлтгэлийн тогтолцооны зэрэг бүх талын иж бүрэн шинэчлэлийг хууль эрх зүйн хүрээний хомсдолын бэрхшээл, төсөв санхүүгийн нэн хязгаарлагдмал нөхцөлийг өөрсдийн оюун ухаанаар даван туулж, хийж чадсан амжилтыг сайд генерал Ш.Жадамбаа болон улс төрч Д.Дорлигжав тэргүүтэй шинэ үеийн залуу сайд нарын удирдаж байсан БХЯ-ны нийт бие бүрэлдэхүүний гавьяа хэмээн энэ өдөр бахархан тэмдэглэх учиртай.

Үүнийг өөрийн хувь заяагаа бусад улсад даатгаж, аль нэг улсаар хамгаалуулах өмнөх тогтолцооны үед баримталж байсан үзэл баримтлалыг халах гэсэн шинэчлэлийн шийдэмгий зорилтын биелэл гэж үзүүштэй.

Монгол Улсын Их



Хурал 1998 онд батлагдан мөрдөж байсан "Төрийн цэргийн бодлогын үндэс"-ийг өөрчлөн "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс" хэмээн нэрлэн 2015 онд баталж, орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах шинэ тогтолцоог бүрдүүлэх, Зэвсэгт хүчнийг мэргэжлийн цэрэгт суурилуулан цаашид хөгжүүлэх төрийн бодлогыг тодорхойллоо.

Ийнхүү монголын төр, Засгийн газар улс орондоо батлан хамгаалах бодлогын нэгэн шинэ үеийг эхлүүлээд байна.

Улс орныг батлан хамгаалах шинэ бодлогод захируулан УИХ-ын тогтоолоор 2016 оноос БХЯ-ыг Монгол Улсын Ерөнхий чиг үүргийн яам болгов. Улсын Их Хурлын эрхэм гишүүн Б.Бат-Эрдэнэ, Н.Энхболд нар бол Ерөнхий чиг үүргийн яам болсон Батлан хамгаалах яамыг анхлан тэргүүлсэн сайд нар юм.

Төрийн шинэ бодлогын үзэл санаанд нийцүүлэн УИХ "Батлан хамгаалах тухай", "Зэвсэгт хүчний тухай" хуулиудыг шинэчилсэн найруулгаар батлан гаргаж, "Орон нутгийн хамгаалалтын тухай" анхдагч хууль, "Дайчилгааны тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" хуулийг батлаад байна. Улсын Их Хурлын 2021 оны хаврын чуулганаар Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Зэвсэгт хүчин нь Хуурай замын цэрэг, Агаарын цэргээс гадна т

Тусгай хүчний цэрэг, Кибер аюулгүй байдлын цэрэг, Барилга-инженерийн цэрэг гэсэн төрийн цэрэгтэй байхаар хуульчиллаа.

Төрийн цэргийн командлал бүр өөрийн цэргийнхээ цэргийн захиргааны удирдлагыг бие даан эрхлэн явуулах боллоо. Сүүлийн жилүүдэд манай яам цэргийн дайчилгааны нөөцийг өргөтгөхөд анхаарч ажиллаж байгаа билээ. Энэ ажлын хүрээнд "Оюутан цэрэг"

хөтөлбөрийг эхлүүлж, амжилттай хэрэгжүүлж байна. Үүнийг харгалзан УИХ цэргийн албаны энэ харилцааг хуулиар зохицуулж өгөв.

Өнөөдөр Монгол Улсын Батлан хамгаалах яам нь нэгд, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог төр, захиргааны байгууллагууд, нийт иргэний оролцоонд тулгуурлан бүрдүүлэх, хоёрт, Зэвсэгт хүчнээ мэргэжлийн чиг хандлагатай болох зорилтоос орчин цагийн мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг болгон хөгжүүлэх зорилтод шилжүүлэх, гуравт, улс орны эдийн засгийн төлөв байдал, Зэвсэгт хүчний гүйцэтгэх үүрэгт нийцүүлэн нэгдсэн удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгааны тогтолцоог төгөлдөржүүлэх гэсэн стратегийн том том зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Улс орныг батлан хамгаалах бодлогын улс төрийн шинэ үйл ажиллагааны стратеги бол улс орны аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангахад үндсэндээ чиглэгдэж, зохих үр дүнд хүрч байна. Манай гадаад харилцааны тэргүүн зэргийн зорилт бол хоёр их хөрш ОХУ, БНХАУ-тай цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлж байгааг онцлон тэмдэглэж байна.

Улс орныхоо тогтвортой хөгжлийг хангах явдал бол батлан хамгаалах чадварыг бэхжүүлэх үндэс болж буй. Иймийн тул юуны өмнө цэрэг, дайчид хийгээд цэргийн техник хэрэгслийг улс орныхоо стратегийн бүтээн байгуулалтад оролцуулах бодлогыг манай батлан хамгаалах яам барьж ажиллаж байгаа юм.

Өнөөдөр манай Зэвсэгт хүчин МАЖЦ, МАА-ийнхаа түүхэн уламжлалыг өртөөлөн авч эх орныхоо бүтээн байгуулалтад оролцож байгаа билээ. Зэвсэгт хүчин Тавантолгой-3 үүнбаян чиглэлийн 416,1 км төмөр замын далангийн суурийн

ажлыг дуусгаж, дээд суурийн тодорхой хэсгийг байгуулж, "Газрын тос боловсруулах үйлдвэр"-ийн хүнд даацын хатуу хучилттай автозамыг барьж байгуулж, ажилчдын орон сууцны барилгыг барьж буйн дээр Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын ажилд оролцож байна.

Манай дайчдын эдгээр болон бусад хөдөлмөр, бүтээлийг монголын ард түмэн сайшаан хүлээн авч байгаад Сайд би баяртай байдгаа энэ ташрамд хэлье.

Манай улсын хувьд хүн амын эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүй, бие бялдрын хүмүүжлийг дээшлүүлэх, нийт иргэд, ялангуяа хүүхэд, залуучуудыг цэрэг, эх оронч үзлээр хүмүүжүүлэх нь улс орноо батлан хамгаалах төрийн бодлогын салшгүй бүрэлдэхүүн хэсэг байсаар байна. Энэ ажлыг бид чанарын шинэ түвшинд гаргахаар ажиллаж байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг "Алсын хараа-2050"-д "Батлан хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлэн, технологийн дэвшлийг нэвтрүүлж, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх" гэсэн том зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Батлан хамгаалах яамнаас 2021 оныг "Үйлдвэрлэгч", "Бүтээн байгуулагч" байх зорилт тавин ажиллаж, тодорхой амжилтад хүрч байна гэж үзэж байгаа. Тухайлбал, Зэвсэгт хүчний инженер, техникийн алба хаагчдынхаа хүчээр хөнгөн хуягласан, тусгай зориулалтын техник, нисэгчгүй нисэх төхөөрөмж, богино долгионы дунд чадлын радиостанц зэргийг зохион бүтээж байгааг БХЯ бүх талаар дэмжин ажиллаж байна.

Анхны эдгээр амжилт бол бид өөрсдийнхөө нөөц бололцоог ашиглан орчин үеийн технологийн ололт, шийдлийг тодорхой хэмжээнд нутагшуулан нэвтрүүлэх, дотооддоо үйлдвэрлэх боломж байгааг харуулж байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчин 2002 онд анх Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс дахь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 2 офицерыг цэргийн ажиглагчаар оролцуулж эхэлснээс хойш 19 жилийн хугацаанд давхардсан тоогоор нийт 19 000 гаруй цэргийн алба хаагч гадаад улс оронд энхийг сахиулах үүрэг гүйцэтгээд байна.

Өнөөдрийн байдлаар БНӨСУ, БНСУ-ын Дарфур, Абей муж, Баруун Сахар, БНАКонгоУ, Йемэн зэрэг 7 улсын нутаг дэвсгэрт яагдаж буй энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс нийт 1100 гаруй цэргийн алба хаагч үүргээ нэр төртэй биелүүлж байгаа бөгөөд НҮБ-ын цэрэг хандивласан 30 орны нэг болж чадсан юм.

Төрийн захиргааны төв байгууллага - Монгол Улсын батлан хамгаалах яам цаашид ч батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг ялалт амжилт өөд залуурдан хөтөлж, Монгол Улсынхаа аюулгүй байдал, тусгаар тогтнолыг батлан хамгаалж, эх орныхоо хөгжил цэцэглэлтэд үнэтэй хувь нэмэр оруулан, өөрт оногдсон үүргээ нэр төртэй биелүүлсээр байх болно гэдэгт итгэл төгс байна.

Эрхэм нөхөд өө!

Монгол Улсын нийт иргэддээ, БХЯ-нд ажиллаж байсан үе үеийн ахмад дайчдадаа, Зэвсэгт хүчний генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, ажилтан албан хаагчдадаа, батлан хамгаалах бодлого, зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө эдүгээ мөр зэрэгцэн зүтгэж байгаа эрхэм хамтран зүтгэгчдэдээ Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын 110 жилийн түүхт ойн баярын мэндийг дахин дэвшүүлж, Та нартаа эрүүл энх, аз жаргал ерөөж, эрхлэн буй ажилд тань амжилт бүтээлийн дээдийг хүсье!

Монгол цэргийн хийморь сүлд мөнхөд мандан бадрах болтугай!

